



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар A/36

Улаанбаатар хот

Г Татварын ерөнхий газрын харьяа нэгж, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн орон тоог шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4, 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоол, 2022 оны 499 дүгээр тогтоолын 6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татварын ерөнхий газрын харьяа нэгж, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн орон тоог хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг харьяа нэгж, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн дарга нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Л.Нэргүй)-т тус тус үүрэг болгосугай.
3. Орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан шаардах хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд хуваарилахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Бямбадорж)-т даалгасугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын 2022 оны А/56 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.ЗАЯАБАЛ

151610433

Татварын өрөнхий газрын даргын
2023 оны 03 дугаар сарын 01-ний
A/36 дугаар тушаалын хавсралт

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ,
ТОМ ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ГАЗАР, НИЙСЛЭЛИЙН ТАТВАРЫН ГАЗАР,
АЙМАГ, ДҮҮРГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ОРОН ТООНЫ ХЯЗГААР

№	Албан тушаалын нэр	Ангилал, зэрэглэл	Орон тоо
22	Дундговь аймгийн татварын хэлтэс		34
	Дарга	T3-4	1
22.1.	Захиргаа, хуулийн тасаг		7
22.1.1	Тасгийн дарга	T3-6	1
22.1.2	Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	T3-7	1
22.1.3	Хуулийн асуудал хариуцсан татварын улсын байцаагч	T3-7	1
22.1.4	Нягтлан бодогч	T3-7	1
22.1.5	Сүлжээний инженер	TY-7	1
22.1.6	Архив-бичиг хэргийн эрхлэгч	TY-5	1
22.1.7	Нярав-үйлчлэгч	TY-4	1
22.2	Бичил татвар төлөгчтэй харилцах тасаг		19
22.2.1	Тасгийн дарга	T3-6	1
22.2.2	Татварын улсын байцаагч	T3-7	2
22.2.3	Утсаар зөвлөгөө өгөх асуудал хариуцсан татварын улсын байцаагч	T3-7	1
22.2.4	Орлогын хяналт, сутган тооцоолол, буцаан олголт хариуцсан татварын улсын байцаагч	T3-7	1
22.2.5	Сумын татварын улсын байцаагч	T3-7	14
22.3	Жижиг татвар төлөгчтэй харилцах тасаг		4
22.3.1	Тасгийн дарга	T3-6	1
22.3.2	Татварын улсын байцаагч	T3-7	3
22.4	Татварын хяналт, шалгалтын тасаг		3
22.4.1	Тасгийн дарга	T3-6	1
22.4.2	Татварын улсын байцаагч	T3-7	2

.---оо---